

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ
“СУВИЛАГЧИЙН НЭГ ӨДӨР” АЯН ЗОХИОН
БАЙГУУЛСАН ТУХАЙ

2017 оны 04 дүгээр сарын 26 ны өдөр

Улаанбаатар хот

“Эх хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулъя” уриан дор олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай ЭМЯ-ны сайдын А/51 тоот, НЭМГ-ын даргын А/30 тоот тушаалын дагуу “Сувилагчийн нэг өдөр” аяныг 2017 оны 03 дугаар сарын 20 ны өдрөөс 04 дүгээр сарын 25 ны хооронд зохион байгуулсан.

Зохион байгуулсан үйл ажиллагаанд нийслэлийн түргэн тусламжийн төвийн нийт сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд бүрэн хамрагдсан.

Ажлын хүрээнд зохион байгуулсан ажлууд:

“Сувилагчийн нэг өдөр” аян зохион байгуулсан тухай:

Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг иргэд үйлчлүүлэгчдэд сурталчлах, таниулах, сувилахуйн тусламж үйлчилгээний мөн чанарыг ойлгуулах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, байгууллага хамт олны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эх хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулъя” уриан дор тусламж үйлчилгээ үзүүлдэг нийслэлийн харъяа 6 дүүргийн хороо, сургууль, цэцэрлэг, айл өрхүүдээс сонголт хийн , зорилтот бүлэг / ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэрийн асаргаа, сувилахуйн тусламж шаардлагатай байгаа иргэд /-д хандан зохион байгуулсан. Үүнд :

Хан уул салбар:

2017 оны 04 дүгээр сарын 13 ны өдөр Хан-уул салбарын сувилагч нар “Сувилагчийн нэг өдөр” аяныг Хан-уул дүүргийн клиник сувиллын 4-р цэцэрлэг дээр зохион байгуулсан. Өдөрлөгт Хан-уул салбарын хүүхдийн их эмч Ж. Ганцэцэг, их эмч Т.Өнөржаргал, 4-р цэцэрлэгийн нийт багш нар хамтран ажилласан.



Өдөрлөгөөр “Тууралтат ба халууралтат хам шинжит өвчин буюу салхинцэцэг, улаанбурхан, улаан эсэргэнэ өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” сэдвээр их эмч Ж. Ганцэцэг, “Нярайн үе ба нярайн онцлог байдлууд” сэдвээр сувилагч Б.Саруул сургалт явуулсан.



Өдөрлөгөөр багш нарт зөвлөмж 20ш, сурталчилгааны хуудас 10ш тус тус тарааж, яслийн ангид 100% чацарганы шүүс 5 литрийг бэлэглэсэн.



Хан-уул салбарын клиник сувилалын 4-р цэцэрлэгийн багш, ажилчид, сургалт явуулж, хамтран өдөрлөг зохион байгуулсанд сэтгэл ханамж өндөртэйгээр талархал илэрхийлж цаашид хамтран ажиллах санал тавьсан. Энэ өдөрлөгийг зохион байгуулснаар бага насны хүүхдүүдтэй ажилладаг багш ажилчдын халдварт өвчний талаарх болон нярай хүүхдийн онцлог шинжүүдийг таньж мэдэхэд тустай эрүүл мэндийн боловсрол дээшилсэн тустай ажил болсон.

Сонгинохайрхан салбар:

2017 оны 04 дүгээр сарын 13 ны өдөр Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Сонгинохайрхан салбарын сувилагч нар “Сувилагчийн нэг өдөр” аяныг

Сонгинохайрхан дүүргийн 26 хорооны Ж. Энхжаргал даргатай өрхийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан. Тус хороо нь нийт 19470 хүн амтай, 4940 өрхтэй. Өдөрлөгт 26-р хорооны их эмч Н. Алтанцэцэг, Н. Мөнхбат болон Сонгинохайрхан салбарын их эмч Г. Алтанчулуун жолооч Н. Анхныбаяр, салбарын сувилагч нар оролцсон. Тус хорооны өрхийн эмчийн санал болгосон ам бүл олон, олон хүүхэдтэй, амьжиргааны түвшин доогуур 4 өрх айлыг сонгон үзлэг хийж, сувилахуйн тусламж үйлчилгээг хүргэж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг хийсэн. Үүнд:



Сонгинохайрхан дүүргийн 26 хороо Баянбулаг 4-24 тоотод оршин суугч иргэн А. Мөнгөө 70 настай, эмэгтэй элэгний хавдартай гэж оношлогоод 2 жил болсон. 2-4 настай 4 хүүхэдтэй охины хамт амьдардаг. Иргэн А. Мөнгөө болон бага насны 4 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийн, зөвөлгөө өгч, тусламж үзүүлсэн.



Сонгинохайрхан дүүргийн 26 хороо Алтан-Овоо 6-19 тоотод оршин суугч иргэн Ц.Дамдинсүрэн 70 настай эрэгтэй, 2017 оны 1 сард халуун усанд бүсэлхийнээсээ доош тахим хүртэл түлэгдсэн арьс нөхөх хагалгаанд ороод 1 сар гаруй болсон, давсанд байнгын гуурс тавиулсан. Энэ иргэнд гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж, цэвэр боолт хийн, катетрийг сольж, асран хамгаалагчид нь цаашид гэрээр хийх асаргаа сувилгааны талаар заавар зөвлөмж өгсөн ба боолтны материал / сальфетик, тамедин, санитол, бинт, бээлий/ зэрэг зүйлээр тусламж үзүүлсэн.



Сонгинохайрхан дүүргийн 26 хороо Алтан-Овоо 2-64 тоотод оршин суугч залуу гэр бүл Жигжидийн 8 сартай хүү, 3 настай охинд үзлэг хийн эхэд нь зөвөлгөө өгөн, хүүхүүдэд гарын бэлэг өгсөн.

Өдөрлөгт зарцуулсан төсөв: Нийт-58500 төгрөг



Энэ өдөрлөгийг зохион байгуулснаар ам бүл олон, олон хүүхэдтэй, амьжиргааны түвшин доогуур иргэдэд эмнэлгийн болон сувилахуйн тусламж үйлчилгээг газар дээр нь хүргэсэн, эрүүл мэндийн боловсрол олгосон тустай ажил болсон.

Баянзүрх салбар:

2017 оны 04 дүгээр сарын 20 ны өдөр Баянзүрх салбарын сувилагч нар "Сувилагчийн нэг өдөр" аяныг Баянзүрх дүүргийн 8 хорооны Нийслэлийн тэргүүний 68- р дунд сургуулийн Оргилтуяа багштай 2в анги дээр зохион байгуулсан. Өдөрлөгт Баянзүрх салбарын их эмч Ж.Дэлгэрмаа хамтран ажилласан. Нийт 29 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, "Амны хөндийн ариун цэвэр", "Гараа хэрхэн зөв угаах", "Гараа хэрхэн зөв ариутгах", "Гар, хөл, амны өвчнөөс хэрхэн сэргийлэх вэ" сэдвийн дор сургалт зохион байгуулж, зөвөлгөө өгөн, зурагт хуудастай тараах материал 35 ширхэгийг тараасан.



Хүүхэд бүрийн тоогоор гар ариутгагчийг тараан өгч сургалтаа эхлэсэн.



Ямар тохиолдолд гарыг угааж ариутгах талаар танилцуулж зөвлөсөн.



Гар угаах аргачлалыг үйлдлийн дагуу зааж сургасан.





Гараа хэрхэн зөв ариутгаж сурсаныг шалгаж үнэлсэн.



Их эмч Ж.Дэлгэрмаа нийт 29 хүүхдэд үзлэг хийсэн.



Эмч, сувилагч нар хүүхдүүдэд амны хөндийн үзлэг хийхэд 29 хүүхдээс эрүүл шүдтэй хүүхэд байхгүй байна. Иймд хүүхдийн эрүүл мэндэд анхаарал тавих эцэг, эхчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажил зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Энэ өдөрлөгийг зохион байгуулснаар сургуулийн бага насны хүүхдүүд халдварт өвчнөөс өөрийгөө хэрхэн сэргийлэх, гарыг угааж, ариутгаж сурахад зөв дадалтай болох, эрүүл мэндийн боловсрол олгосон тустай ажил болсон.

Төв салбар:

2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Төв салбарын сувилагч нар "Сувилагчийн нэг өдөр" аяныг Нийслэлийн түргэн тусламжийн төв дээр зохион байгуулсан. Өдөрлөгт ЧДЭМН-ийн сувилахуйн албаны дарга Г. Нямгэрэл хамтран ажиллаж "Нярай болон бага насны хүүхдийн сувилахуйн үнэлгээ" сэдвээр сургалт зохион байгуулсан.



Өдөрлөгийн арга хэмжээнд эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, захиргаа үйлчилгээний ажилтнууд нийт 82 хүн хамрагдсан.



Өдөрлөгийг сувилагч мэргэжлийг сурталчлах, сувилахуйн тусламж үйлчилгээний мөн чанарыг ойлгуулах, мэдээлэл өгөх, байгууллага хамт олны оролцоог нэмэгдүүлэх сувилагч нарын ёс зүй, уялдаа холбоог сайжруулах, харилцан туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан. Өдөрлөгт оролцсон нийт хүмүүсийг халуун чацаргана, аарцаар дайлж, витаминжуулалтанд хамруулсан.



Өдөрлөгийн хүрээнд: Нийт 187 хүн хамруулж, 70ш зөвлөмж, зурагт хуудас тарааж, 160600 төгрөгний эм, эмнэлгийн хэрэгсэл, гарын бэлгийг хүүхдүүдэд өгсөн. Мөн 200ш витамин тараасан. Хийсэн ажлын тайланг байгууллагын вэб сайтанд байршуулж сурталчилсан.

ТАЙЛАН БИЧСЭН:

СУВИЛАХУЙН АЛБАНЫ ДАРГА

Б. ТАНАЦЭЦЭГ